



ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН БАРИЛГЫН АРХИТЕКТУРЫН ЗАРИМ АСУУДАЛ



С.БААСАНДОРЖ

*Хууль сахиулахын их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
231-р дамжааны сонсогч*

Монгол улс хорих ялын эрх зүйн болон хорих ял эдлэгсдийн барилгын хийц хэлбэрийн хөгжилийн хувьд харьцангуй бага түүхтэй бөгөөд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гарах үед (хар гэр) дараагаар нь 1926 онд батлагдсан эрүүгийн хууль, 1931 онд батлагдсан аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажилын тухай хуулиар зохицуулагдсан Гяндан хорих газар бүхий хорих ял эдлэгсдийн барилга байгууламжийн үндсийг бий болгосноос хойш 90 гаруй жил өнгөрч байна.

Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Монгол улсын хууль зүйн яам 2012 онд хорих ял эдлэгсэдийг ял эдлүүлэх буюу шоронг шинэчлэн барих санаачлага гаргасан билээ. 2006 оноос хойш одоог хүртэл ял эдлэгсдийн орчин нөхцөлийг дэлхийн жишигт нийцүүлэх шоронгийн барилга байгууламжийг барих ажил хийгдсэн бөгөөд нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарснаар хөгжлийн шаардлагад нийцүүлэн шоронгийн барилгын хийц загвар, чанарт зарим өөрчлөлт хийх шаардлагатай болж байна.


1. Монгол улсад хорих ял эдлэгсдийн барилгын архитектурын байдал

Хорих ялыг насанд хүрсэн, ба насанд хүрээгүйчүүдийн, эмэгтэйчүүдийн гэх мэт нас хүйсийн байдлыг харгалзан тус тусад нь ял эдлүүлхээс гадна өөр хоорондоо дэглэмийн ялгаагаар эдлүүлдэг байна.

Өнөөдрийн байдлаар Монгол улсад нийт 42 хорих анги, цагдан хорих болон баривчлах байр байна. Үүнээс төвлөрсөн хорих анги 25, баривчлах цагдан хорих байр 26 байна.

- Гяндан 1, /94/
- Онцгой 1, /199/
- Чанга дэглэмтэй хорих 11, /2918/
- Жирийн дэглэмтэй хорих 12, /3732/
- Баривчлах ял эдлүүлэх анги 1, /64/
- Баривчлах ял эдлүүлэх байр 13, /102/
- Цагдан хорих байр 25 /1295/⁴²

⁴² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 2012 УБ хот



Хорих байгууллага дахь хяналт, харуул хамгаалалтад хэт богино долгионы радиостанц, телекамерийн тоног төхөөрөмж ашиглаж болно. Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан,⁴³ амьдралын болон үйлдвэрлэлийн бүсийн гаднах дохиолол, харуул хамгаалалтыг хорих байгууллагын ажилтны

хүчээр хариуцан гүйцэтгэнэ. (Анхны хорих байр)

Дэглэм бүхий хорих ангиуд нэг хийц загвартай баригдсан байна. Төвлөрсөн хорих анги:

(Гадна)




(Дотор)




Цагдан хорих төв

(Гадна)



(Дотор)



⁴³ Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. Жирийн дэглэмтэй хорих анги нь үндсэн хашааны эргэн тойронд хоёроос доошгүй хамгаалалтын бүстэй байна.

Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан хамгаалалтын дараахь бүстэй байна:

1. Дотоодын хориотой бүс;
2. Телекамер;
3. Үндсэн хашаа;
4. Цахилгаан дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс;
5. Өнгөлөн далдлах хашаа;




Архитектур гэдгийг барилга байгууламж нөгөө талаас төлөвлөлт гэж ойлгож болохоор байна. Барилга байгууламжид орон зай, зам талбай, зохион байгуулалтын нөхцөл байдалтай уялдуулан тодорхой хэмжээний төлөвлөлтийг онцлогийг хамааруулдаг байна. Монгол улсад оршин тогтнож буй хорих байгууллагын барилга байгууламж өнөөдөр аль хэдийнээ хэрэгцээ шаардлагаа хангахаа больжээ. Энэ нь хорих байгууллагаар дагнасан судалгаа хийдэг судалгааны төв байхгүйгээс болоод Монгол улсын хорих байгууллагын хөгжил нэлээд удаашралтай явагдаж байна. Тиймээс өөрийн гэсэн судалгааны төвтэй болох нь ихээхэн ач холбогдолыг өгөх нь ойлгомжтой. Үүнийгээ дагаад судалгааны төвийг чиглэл чиглэлээр нь ангилах хэрэгтэй.



Барилгын архитектурчдыг бэлтгэх:

- Хорих байгууллагын зураг төслийг гарган боловсруулах, барилгыг босгох болон, бусад биетийн бүтэц байгуулалтын талаарх шинжлэх ухаан болон урлагтай холбон бүтээх.
- Хорих байгууллагыг байгаль орчинд босгох барилгаа мэргэжлийн үйлчилгээнүүдтэй хамтад нь босгох.



- Барууны өндөр хөгжилтэй оронд хорих байгууллагын архитектур уран барилгач хүний макро түвшнээс (хотын үзэмж, архитетурын шийдэл) микро түвшин (детальчилсан бүтэц, байгуулалт, өрөөний зохион байгуулалт гэх зэрэг) хүртэлх барилга, байгууламжийн зураг төслийн үйл ажиллагааг бий болгодог тийм бол монгол улсын хорих байгууллагад яагаад байж болохгүй гэж. 1. Хананы зузаан 40 см; 2.Телевиз⁴⁴ 3.Ор; 4.Сандал;

5.Угаалтуур; 6.Хаалга; 7.Давхар хаалга;

⁴⁴ Гаргах суваг хязгаарлалттай алсын зайны сургалт болоод хүлээн зөвшөөрөгдсөн сувгууд хувиарын дагуу явагдана;



- Хорих байгууллагын харуул хамгаалалтанд ямар төрлийн систем, тогтолцоо зэргийн зураг төслийг боловсруулах зэргийн нэршил.

Хорих байгууллагын барилга, архитектурын хамаарал нь барилга, байгууламжийг төлөвлөн, зураг төслийг боловсруулах зэргийг гүйцэтгэхдээ:

1. Орон зайн хувьд байгаль орчин; /орон нутаг, хот/
2. Нийгэмтэй ойр;
3. Техник болон;
4. Гоо зүйн хувьд нь тэдгээрийн хэвийн нөхцлийг хангахад зөв байхаар сайтар бодож, төлөвлөх юм.

Шинжилгээний төв бий болгох:

Хорих байгууллагын барилгийн шинжилгээний төвийг бий болгосноор тухайн хорих байгууллагыг барьхад бий болгох барилгын орц найрлагыг тогтоох. Жишээ нь: Элс, шороо гээд л байж болох бүхийл зүйлийг шинжилснээр эрүүл орчин, үүнийгээ дагаад аюулгүй байдлыг бий болгох ихээхэн ач холбогдолтой.

Гүйцэтгэлийн ажлыг тусдаа ажилчдаар бий болгох:

Зураг төсөл боловсруулсан архитекторчдын зураг төслийг үндэслэн, ийнхүү шинжилгээний төвөөс өгсөн барилгын орцыг түшиглэн тухайн байгууламжийг барих ажлыг тусдаа ажилчдаар бий болгон сүндэрлүүлэх.

Шинжилгээн судалгааны төв бий болгох

Барилгын архитектурчдыг бэлтгэх

Үр дүн-----→ Барилга байгууламжаар хорих ангийн харуул хамгаалалт сайжрах -----→ Хүний эрхийг хангасан эрүүл орчин бий болох

Монгол улсын Эрүүгийн хариуцлагын тухай хуулийн шинэ төсөлийн⁴⁵ 31 дүгээр зүйлд хугацаатай хорих ялын хэлбэрийг хотын төвд хэрэгжүүлэх боломжтой. Хотын төвд нэг төвлөрсөн хорих байгууламж барьж, 31.2 –т зааснаар өдөр нь хорих байгууллагыг орхин явах боломжтой нээлттэй дэглэмийг хөгжүүлэх боломжтой. Ингэснээр хорих ангид ял эдлэж буй ялтнууд өдрийн цагаар үр бүтээлтэй өндөр цалинтай ажил хийх, ялтнуудыг хорих байгууллага батлан даах энэхүү системийг хөгжүүлэх боломжтой. Ингэснээрээ хорих байгууламжийн байршил эдийн засгийн болоод хорих ангид ял эдлэж буй ялнуудыг нийгэмшүүлэх олон талын ач холбогдолыг өгч чадна.

Гадны өндөр хөгжилтэй орнууд шорон судлал гэдэг зүйл байдаг. Энэхүү судлал нь байснаар хорих байгууллагын хөгжилийн чиг хандлагыг тогтоохоос гадна гэмт хэргийн тоон үзүүлэлтийг бууруулах боломжтой юм.

⁴⁵ Монгол улсын Эрүүгийн хариуцлагын тухай хуулийн шинэ төсөл УБ хот 2012 он 31 дүгээр зүйл. Хугацаатай хорих

31.1. Нэг сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай дэглэм бүхий байранд нийгмээс тусгаарлан хугацаатай хорих ялыг эдлүүлнэ.

31.2. Тохиолдлын шинжтэй, анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүн, хүүхэд, эмэгтэй хүнийг нийгмээс бүрэн тусгаарлахгүй, ажил эрхлэх, сургуульд суралцах, гэр бүлтэйгээ уулзах зорилгоор хорих байгууллагыг түр орхин явах боломжтой нээлттэй дэглэмд хорих ял эдлүүлнэ.



2. Гадаадын зарим орны хорих ял эдлэгсдийн барилгын архитектурын байдал;

Архитектур гэдгийг барилга байгууламж нөгөө талаас төлөвлөлт гэж ойлгож болохоор байгааг дээрх бүлгээс харлаа. Барилга байгууламжид орон зай, зам талбай, зохион байгуулалтын нөхцөл байдалтай уялдуулан тодорхой хэмжээний төлөвлөлтийг онцлогийг гадаадын өндөр хөгжилтэй оронд хөгжүүлсэн нь өөрийн гэсэн судалгааны төвтэйн давуу байдлыг үүсгэж байна.


Барилга архитектур, дизайн гэсэн хоёр ойлголтыг салгаж авч үзэж болохгүй бөгөөд бие биетэй нь хамаатуулан авч үздэг. Одоогоор бол Францийн шоронгийн архитектур хамгийн уран сэтгэмжтэй байна. Америк Английн загварыг илүү шинжлэх ухааны үндэслэлтэй, орчин үеийн загвар хийцтэй гэж үздэг.

Судалж үзсэн зарим гадаад улсуудад:

- Шорон судлалын шинжлэх ухааны төв бий болгосон.
- Шоронгийн барилгын архитекторчдын ажиллах нөхцөлийг хангасан.
- Эрх зүйн зохицуулалтанд нь өөрчлөлт хийсэн зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Германы хорих байгууллага:

Герман улсын шоронгийн архитектур нь өөрийн гэсэн өвөрмөц шинжийг агуулсан байдаг. Тэр дундаа шоронг анх ямар загвартай барьж, байгуулж байсан нь түүхийн хуудаснаа үлдсэн байдаг. Герман улсын хорих ангийн аюулгүй байдалын гол харуул хамгаалалт нь архигтектурт асуудал нь ихээхэн анхаарал хандуулж ирсэн. Ихэвчлэн загвар хийцийн хувьд тойрог хэлбэртэй бөгөөд энэ нь хоригдлуудыг оргон зайлахаас урьдчилан сэргийлсэн, төөрөгдүүлэх, тусгай техник хэрэгслээр тоноглогдсон хашаатайгаар хийж цогц арга хэмжээг байгуулсан байна.



*АНУ-ийн HARDEST 1881 оны 6 сарын 12 –нд №244,358
/зураглал/ хорих ангийн*



АНУ-д хорих ангийг дотор нь харуул хамгаалалтыг нь харгалзан:

1. Minunem prison security-Жирийн хамгаалттай бүс
2. Medenum prison security- Дунд зэргийн хамгаалттай бүс
3. Maximum prison security- Чанга хамгаалттай бүс⁴⁶
4. Extreme prison security- Онцгой хамгаалттай бүс⁴⁷

Зохион байгуулалтын хувьд дараах хэлбэртэй байна:

1. Хорих ангийн зоонруу орох кордиор /8/⁴⁸
2. Тухайн зоонуудыг тусгааралсан дууний хамгаалалттай бүхий хана./8/⁴⁹
3. Зооноос гарах хаалга /1/⁵⁰
4. Зооны гаднах хашаа 7м өндөртэй;

Жишээ нь: Extreme prison security⁵¹- д бүсээр хувааж өгсөн байдаг.

Үүнд:

1. East- Цэнхэр өнгийн хувцастай ялтнууд;
 2. West- Улаан өнгийн хувцастай ялтнууд;
- Хорих байгууллагад үймээн, бослого гарахад тухайн ялтнууд бие биенээ таньдаггүйн бүсүүдэд хуваасантай холбоотой байдаг. Наралгаа уулзалт зэргийг бүс бүсээр нь цагийн хувиарын дагуу явуулдаг.
- Геометрийн шинжлэх ухаан, архитектурын шинжлэх ухааныг бид эрх зүйн шинжлэх ухаантай холбосноор зарим асуудлыг шийдэх боломжтой.

Судалгааны дүгнэлт

“Их зорилго далд бүхнийг ил болгодог”

Нийгэм хөгжихийн хэрээр гэмт хэргийн өсөлтийг улам нэмэгдүүлж, нарийсах нэг шалтгаан болдог. Тэгвэл нийгэмээ дагаад хүний оюун ухаан мөн адил хөгжиж байдгын адилаар, гадаадын өндөр хөгжилтэй орны хорих ангиас оргох гэмт хэрэг хоригдлын тоо ихээхэн байдаг. Тийм ч утгаараа манай орны хувьд хорих ангиас оргох асуудал сүүлийн жилүүдэд цөөнгүй дуулдах болсон нь иргэдийг амгалан тайван байдлыг алдагдуулж нийгмийг айдаст автуулж олон хүний амь нас эрүүл мэнд хохирогч байсан тохиолдол цөөнгүй байна.

Аливаа эрх зүйн орчноо боловсронгуй болгон, сайжруулснаар бүх асуудлыг шийдвэрлэнэ гэвэл учир дутагдалтай. Харин бусад шинжлэх ухааны салбартай уялдуулан түүний ололт амжилтыг бүтээлчээр нэвтрүүлэх нь практикт тулгамдаж

⁴⁶ Hardest prison security гэсэн нэр томъёо хамт явдаг.

⁴⁷ Ялангуяа “Extreme prison security” –г ихэвчлэн хорих ангийг нь тойрог хэлбэртэй барьдаг байсан байна.

⁴⁸ Зоонруу орох корпусаар нь “Extreme prison security” –д 8 байх бөгөөд түүнээс дээш байдаггүй. Хамгийн том хорих ангид дээд тал нь 8 байдаг. Харин “Maximum prison security”-д 4 байна.

⁴⁹ Ялтануудыг гэмт хэрэг үйлдхээс урьдчилан сургийлэх, таслан зогсоох зорилготой дуу тусгаарлагч хийсэн байдаг.

⁵⁰ Зурагт үзүүлсэнээр гадагш гарах хаалга 1 л байна.

⁵¹ Онцгой дэглэмтэй хорих анги



буй асуудлыг даван туулах арга замын нэг гарц болж өгдөг. Тиймээс судлаач оюутны байр суурьнаас дараах саналыг дэвшүүлж байна.

Санал:

1. Шинжилгээний төв бий болгох: Хорих байгууллагын барилгийн шинжилгээний төвийг бий болгосноор тухайн хорих байгууллагыг бархад бий болгох барилгын орц найрлагыг тогтоох. **Жишээ нь:** Элс, шороо, блок, тоосго, **ханыг цутгаж хийх** гэх мэт зүйлийг шинжилснээр эрүүл орчин, үүнийгээ дагаад аюулгүй байдлыг бий болгох ихээхэн ач холбогдолтой.

А. Барилга байгууламжийг бий болгохдоо дэглэмээс нь шалтгаалан барилгын зураг төслийг гаргах.

Б. Гүйцэтгэлийн ажлыг тусдаа ажилчдаар бариулах: Зураг төсөл боловсруулсан архитектурчдын зураг төслийг үндэслэн, ийнхүү шинжилгээний төвөөс өгсөн барилгын орцыг түшиглэн тухайн байгууламжийг барих ажлыг тусдаа ажилчдаар бий болгон сүндэрлүүлэх.

2. Төвлөрсөн шинжтэй барих. Бүтээн байгуулалтаа бий болгохдоо ангилан зохион байгуулах шаардлагатай. **Жишээ нь:** Анх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих анги нэг төвлөрсөн байх. Үүнд ямар гэмт хэрэг үйлдсэн нь хамаагүй үйлчилнэ.

А. Ангилан хувиарлах хэсэг хорих ангид нь бий болгох. Хувиарлагдаж ирсэн хоригдлуудыг ял эдлэх ангид ирмэгц тухайн нөхцөл байдалд дасгах зорилгоор сар гаран ганцаарчлан хорино. Түүний дараагаар зан байдлыг ажин ямар ангилалд оруулхыг шийдэх.

Б. Хорих ангийн өрөөний зохион байгуулалтанд анхаарал хандуулах.

В. Хорих ангид шинэ төхөөрөмж суулгах. 1. Цагдан хорих болон, хорих байгууллагуудын телехяналтын систем нь одоогийн нөхцөлд шинэчлэх илүү дэвшилттэй технологийг нэвтрүүлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ байдал нь харуул хамгаалтын ажилд сөргөөр нөлөөлж болох талтай. 2. Автомат цоожлох систем. Жишээ нь солонгосын хорих ангийн.

Г. Засрах найдлагтай ялтнуудыг. Өдрийн цагаар нийтээр нь ажилуулж, орой нь тэднийг тусгаарлах. Гадуур ажил эрхлэх зэрэг нилээд хөнгөлөлтийг эдлүүлэх урамшуулах.⁵²

⁵² Ялтанг суллагдах үед заавал ажилын байраар хангах. Энэ нь иргээд нийгэмшихэд нь хэрэг болох. Мэргэжлийн байгууллагуудыг хамтран ажиллахад идэвхтэй оролцуулах. Нэг жил хүртэл хорих ялаар шийтгүүлсэн этгээдэд мэргэжлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулах, боловсрол олгох, гэр бүлтэйгээ харилцаа холбоотой байх боломж олгосон хагас эрх чөлөөтэй байх ял тухайн этгээд засарч хүмүүжихэд нөлөө үзүүлдэг байна.